



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/516

Эрдэнэт

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 1.1.9.1, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын одоогийн түвшинг тогтоож, халдварт бус өвчнөөс сэргийлэх цаашдын төлөвийг тодорхойлох ажлын удирдамж, судалгааны баг, ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шаардагдах зардал 3800000 /Гурван сая найман зуун мянган / төгрөгийг "Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа хийх, үр дүнг тооцох зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, тандалт судалгаа, халдварт бус өвчнөөс сэргийлэх цаашдын төлөвийг тодорхойлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар/н.Баттүвшин/-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 05-ний өдрийн
516 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт



**ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН
ТАРХАЛТЫН СУДАЛГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Зардлын бүлэг	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Үзүүлэлт
1	Оношлуур	Сахар хэмжигч аппарат	1	46 000	46000	Glucolab AC
2		Сахарын тест	4	30 000	120000	Glucolab AC №50
3		Холесторлын аппарат	1	125 000	125000	
4		Холесторлын тест	8	87 500	700000	№25
5		Зүү	4	2500	10000	Greenlan №50
6		Тарианы хөвөн	5	500	2500	№12
7		24 цагийн шээсэн дэх давс, натрийн агууламжийг тодорхойлох	224	3000	672000	
		Шээс хэмжих сав	5	5000	25000	
		Шээс цуглуулах сав	100	2000	200 000	
		Нийт				1 900 500
7	Бичиг хэрэг	Бичгийн цаас	2 боодол	9500	19000	
8		Хэвлэх машины хор	1	60 000	60000	
8		Бал	50 ш	300	15000	
9		Судалгааны үр дүнг хэвлүүлэх	49 ш	5500	269 500	/4 хуудас/
		Нийт				363 500
10	Хүний нөөцийн зардал	Судалгааны мэдээлэл цуглуулах	5 хүн	200 000	1 000 000	
11		Судалгааны шивэлт, үр дүнгийн боловсруулалт	2 хүн	50 000	100 000	SPSS-20.0 программд шивэлт хийж боловсруулалт хийнэ
12		Судалгааны зөвлөх	1 хүн	100 000	100 000	АШУУИС-ийн багш
14		Нийт				1 200 000
16	Урамшуулал	Судалгаанд оролцогчдын урамшуулал	224	1500₮	336000	
Бүгд					3 800 000	